



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.22 № 09/31 УНГ-СӨГ/2013/18-СГА-ТТЗ.

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Тагнуулын ерөнхий газрын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Үндэсний тагнуулын академи 2012 оны санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанаас хоцроож УАГ-т аудит хийлгүүлэхээр 2013 оны 3 дугаар сарын 13-д ирүүлсэн байна. Тус академи 2012 оны санхүүгийн тайланд сургалттай холбоотойгоор 134,0 сая төгрөгийн орлого олсон гэж бүртгэсэн боловч сургалтын төлбөрийг хүн бүрээр авлага, өглөгийн тооцооллыг хийж бүртгэлд тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл сургалтын орлогыг сургалтын жилийн хугацаа, төсвийн жилийн хугацаа зөрүүтэй байхад орлогыг аккурель сууриар бүртгэдэггүй, сургалтын орлогын талаар дэлгэрэнгүй бүртгэлийг хийдэггүй, хяналтгүй байна. Хичнээн хэмжээний сургалтын орлого орохоос хэд орсон, хэдийг хэнгээс авах нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д "санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.


Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих" гэж заасныг үндэслэн сургалтын орлогын дэлгэрэнгүй бүртгэлийн хийж холбогдох журналуудыг хөтлөн дээр дурьдсан зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2013 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус академийн нягтлан бодогч Г.Батчимэгт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР**

ЗӨВШӨӨРСӨН:

УТА-ЫН НЯГТЛАН БОДОГЧ



Л.ОДГЭРЭЛ

Г.БАТЧИМЭГ

070090